



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



ТЕЛЕВИЗИЙН I, II, III ЦАРААНЫ АШИГЛАЛТЫН БАЙДАЛ ЦААШДЫН ХАНДЛАГА

Боловсруулсан: ХХЗХ-ны РДЗХА-ны мэргэжилтэн Ч.Тэрбиш

Улаанбаатар 2015

ГАРЧИГ

1. ОУЦХБ¹-ын 1-Р БҮСИЙН ЕВРОПЫН ОРНУУДЫН РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ	1
1.1 ФМ ² зурваст радио давтамжийн дутагдалтай байдал	1
1.2 Радиогийн тоон технологид шилжих үйл явцын талаар.....	1
1.3 87.5-108 МHz зурваст тоон радиогийн шилжилт хийх боломж.....	2
1.4 Тоон технологид шилжүүлэх төлөвлөгөө	2
1.5 Европын орнуудын РӨН ³ салбарын байдал.....	2
1.5.1 Судалгааны хэсгийн саналууд.....	3
1.6 Европын орнуудад шилжилтийн талаарх нөхцөл байдал.....	4
2. ТООН РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ИРЭЭДҮЙ	4
2.1. Европын орнуудад баримтлах чиглэл	4
2.2 Улс орнуудын санал	9
3. МОНГОЛ УЛСАД VHF I, II, III ЗУРВАСЫН РАДИО ДАВТАМЖИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	10
3.1 VHF I,II,III зурвасын талаар гарсан тогтоол.....	11
3.2 Монгол Улсын стандартууд.....	12
3.3 Шилжилтийн үед VHF I,II,III зурвасуудад баримтлах зарчмын талаар саналууд.....	12
3.4 Шилжилтийн талаар ажлын хэсгийн саналууд.....	13
4. ДҮГНЭЛТ	14
4.1 Зурвас I (47-68 МГц).....	14
4.2 Зурвас II (87.5-108 МГц).....	14
4.3 Зурвас III (174-230 МГц).....	14
5. ХАВСРАЛТ	16
5.1 Зурвас I (47-68 МГц).....	16
5.2 Зурвас II (87.5-108 МГц).....	17
5.3 Зурвас III (174-230 МГц).....	23
6 АНГЛИ ОРЧУУЛГА	23-33

¹ Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага

² FM-Frequency modulation

³ Радио өргөн нэвтрүүлэг

ТЕЛЕВИЗИЙН I, II, III ЦАРААНЫ АШИГЛАЛТЫН БАЙДАЛ

ЦААШДЫН ХАНДЛАГА

1. ОУЦХБ⁴-ЫН 1-Р БҮСИЙН ЕВРОПЫН ОРНУУДЫН РАДИО ӨРГӨН

НЭВТРҮҮЛГИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

Европын улсууд 2010 онд RSPG⁵ 10-316 ажлын хэсэг байгуулж энэ зурвасуудад баримтлах бодлогын чиглэлээ тодорхойлсон байна. Ажлын хэсэг гишүүн улс орнуудад улс орнуудын бодлогын чиглэл, зах зээлийн асуудлууд, тоон технологийн шилжилтийн байдал, спектрийн ашиглалтай холбоотойгоор 2 асуудлыг дэвшүүлж санал авсан. Европын холбооны гишүүн 24 улс орнуудын ирүүлсэн хариултууд нь ажлын хэсгийн судалгаанд чиглэл олгосон.

Спектр ашиглалттай холбоотой дараах асуудлуудыг анхаарсан:

1. Өнөөгийн хэрэглээний байдлыг тодорхойлох;
2. Салбарын судалгаанд үндэслэн хэрэгцээ шаардлагуудыг тогтоох;
3. VHF⁶ 1.5 ГГц–ийн стратегийн хүчин зүйлсүүдийг тодорхойлох;
4. Тодорхойлсон болон санал болгосон зүйлс нь цаашдын хөгжилд ямар нөлөө үзүүлэх;

Нэгдүгээрт: Тоон технологийн шилжилт нь улс төрийн сонирхолд хөтлөгдөж хийгддэг.

Хоёрдугаарт: Зах зээлийн шаардлага, үйл ажиллагаа эрхлэгчид, зохицуулалтын байгууллагын хамтын ажиллагаа маш чухал байдаг.

Гуравдугаарт: Хэрэглэгчдийн санаа бодол хамгийн чухал асуудлын нэг байдаг.

Дэлхийн улс орнуудад одоо хэрэглэгдэж байгаа технологиудаас 27 МГц –ээс доош давтамжийн зурвасуудад DRM⁷ болон HD⁸ радио стандартууд гарсан. Харин тайланд 47-68 МГц-ийн (зурвас I)⁹, 87.5-108 МГц (зурвас II)¹⁰, 174-230 МГц (зурвас III)¹¹, 1452-1479.5 МГц (зурвас L)¹² өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнүүдэд ашиглагдаж байгаа зурвасуудын ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байна.

1.1 ФМ¹³ зурваст радио давтамжийн дутагдалтай байдал

ФМ зурвасын дууны чанар хангалттай сайн байдаг ч радио давтамжийн нөөцийн хувьд цаашдын хөгжил нь хязгаарлагдсан байдаг. Ийм ч учраас олон улсад ФМ радиогийн технологийг зогсоож тоон технологид шилжих явц дунд болон урт хугацааны төлөвлөлтэйгээр хийгдэж байна.

1.2 Радиогийн тоон технологид шилжих үйл явцын талаар

⁴ Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага

⁵ Radio Spectrum Policy Group

⁶ Very high frequency

⁷ Digital Radio Mondial

⁸ High Definition

⁹ Band I

¹⁰ Band II

¹¹ Band III

¹² Band L

¹³ FM-Frequency modulation

Тоон радиогийн шилжилтийн процесийг таамаглан хянах боломжгүй байна. Аналог хүлээн авагчийн зах зээл дэх борлуулалтын хэмжээ тоон радио хүлээн авагчийн борлуулалтын хэмжээтэй харьцуулшгүй их хэмжээтэй байсаар байна. Европын орнууд тоон радиогийн стандартын сонголтыг ижил байлгах, аль болох хямд үнэтэй хүлээн авагч төхөөрөмжийг хэрэглэгчдэд хүргэх үндсэн чигийг баримталж байна. Харин дэлхийн бусад бүс нутгуудын хөгжиж буй орнуудад аналог радиогийн хамрах хүрээг нэмэгдүүлсээр байгаа билээ. Эдгээр орнуудын зохицуулагчид технологийн шинэчлэлийг одоогийн ашиглаж байгаа зурваст нь хэрэгжүүлэх АНУ¹⁴-ийн адил бодлого баримталж байж болох юм. Гэвч технологийн шилжилтийг эрчимжүүлэх санхүү, эдийн засгийн туслалцаа фм радиогийн системийн хувьд байх нь хүндрэлтэй юм.

1.3 Радио давтамжийн 87.5-108 MHz зурваст тоон

радиогийн шилжилт хийх боломж

Европын зах зээл дэх ФМ хүлээн авагчийн хэрэглээ өндөр хэвээр байсаар л байна. Бүх автомашины хөгжим ФМ хүлээн авагчтай үйлдвэрлэгдэж байна. DAB хүлээн авагчтай хосолсон хэлбэрээр ч ашиглагдаж байна.

1.4 Тоон технологид шилжүүлэх төлөвлөгөө

Зарим улс орнууд хугацаа товлосон урт дунд хугацааны төлөвлөлтөөр ФМ радиогийн тоон шилжилтийг зурвас II -д хийхээр урт хугацаанд төлөвлөсөн байна. Зарим улсууд эрх зүйн шинэчиллийг тоон шилжилттэй холбогдуулан хийж байна.

1.5 Европын орнуудын РӨН¹⁵ салбарын байдал

Европын холбооны судалгааны хэсгээс салбарын байдлын талаарх асуулгыг 4 асуудал дээр авч үзсэн. Стандартын сонголтын тухайд ЕХ¹⁶-ны гишүүн улс орнууд болон олон улсын байгууллагууд ямар байр суурьтай байгаа талаар дурдвал:

DRM-Digital Radio Mondial

Нэг стандартыг сонгох буюу эсвэл тохиромжтой холимог хувилбарыг Европын улс орнууд сонгох нь зүйтэй.

Satellite Action Plan regulatory Group

SAP REG –ийн ирүүлснээр Радио өргөн нэвтрүүлгийн цаашдын хөгжил дэвшилд сансрын холбоо ашиглах нь ихээхэн дэвшил авчирна гэдэгт итгэлтэй байна гэжээ. L зурваст Европын улс орнуудад олон төрлийн технологийн төхөөрөмж ашиглах нөхцлийг бүрдүүлж байгааг тэмдэглэсэн байна тухайлбал CEPT ECC/DEC/(03)02. Урт хугацааны хөрөнгө оруулалт шаардагддаг учраас энэ зурвасын зохицуулалт их чухал байдаг гэжээ.

European Telecommunications Standardizations Institute

Хямд бөгөөд чанартай хүлээн авагч төхөөрөмжөөр сонсогчдыг хангахыг чухалчилах шаардлагатай гэв.

European Broadcasting Union

¹⁴ Америкийн Нэгдсэн Улс

¹⁵ Радио өргөн нэвтрүүлэг

¹⁶ Европын Холбоо

DAB/DAB+, DRM/DRM+ тоон радиогийн стандартуудыг хэрэгжүүлэхэд хүлээн авагчийн зах зээлийн нийлүүлэлтийг бэлтгэх нь ихээхэн чухал байна.

Association Europeenne des Radios

Тоон радиогийн шилжилтийн процесс нь ихээхэн урт хугацаанд явагдах төлөвтэй байна. Улс орнууд шийдвэр гаргаж шилжилт хийхээс бус ихээхэн хугацаанд үргэлжилэх процесс.

Digital Europe

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг тоон технологийн шилжилтэд чиглүүлэн дэмжих үүний тулд зах зээлийн нөхцөл байдал (хүн ам, газар хамрах хүрээ, контентийн боломжууд) зэрэг хүчин зүйлсийг тодорхойлох шаардлагатай.

Польш Улсын тоон радиогийн форум

Засгийн газрын зохицуулалтын хувьд хэрэглэгч, контент үйлдвэрлэгч, өргөн нэвтрүүлгийг дамжуулагчид уг сонгож авсан платформыг урт хугацаанд тогтвортой ашиглагдана гэдэгт итгэлтэй байлгахад анхаарах хэрэгтэй гэж үзсэн. Хүлээн авагч төгсгөлийн төхөөрөмжийг хямд үнэтэй байлгах нь тоон технологийг хурдан хугацаанд нэвтрүүлэхэд чухал юм.

World DMB Forum

Тоон технологид шилжүүлэх шилжилтийн процесс нь оролцогч бүх талуудын сонирхолд нийцэж байхуйц шилжилтийн төлөвлөгөөтэй байх хэрэгтэй. Тоон радиод шилжих үйл явц Европын олон улс орнуудад хэрэгжиж эхэлсэн бөгөөд ийм төлөвлөгөөтэй байх нь сонсогчдод эерэг зөв зүйтэй мэдээллийг өгч шилжилтийг хохиролгүйгээр хийхэд ач холбогдолтой.

1.5.1 Судалгааны хэсгийн саналууд

Европын холбооны нэгдсэн санал

EX¹⁷ ны RSPG(Radio Spectrum Policy Group)-ийн үзэж байгаагаар EX-д өргөн хүрээтэй стратегийн төлөвлөгөөтэйгээр зах зээлд оролцогч талуудыг татан оролцуулах шаардлагатай. (Жишээлбэл: Төлөвлөгөөний дагуу автомашин үйлдвэрлэгчидтэй хэрхэн автомашины хүлээн авагчийн үйлдвэрлэлээр хамтран тухай асуудал г.м) Судалгааны хэсэг одоогийн олон улсын хэлцлүүдтэй (St61, GE84 болон GE06 хэлцлүүдтэй DRM+) нарийн зурвасын системүүд зохицох ажиллах талаар техникийн аргагчиллыг санал болгосон.

Тоон радиогийн үйлчилгээний талаар (контент)

EX-ны олон талаас дүгнэн шинжилсэн судалгааны дүнгээр хамгийн тохиромжтой хувилбарыг T-DAB¹⁸ төрлийн стандартууд гэж үзэж байна. Өөр нэг хувилбар болох нарийн зурвасын систем болох DRM+ (Band I, II, III) байж болох юм. Судалгааны багийн зөвлөснөөр тоон радиогийн контентуудыг хүргэхэд техникийн хүндрэл хамгийн багатай хувилбарыг сонгох нь зүйтэй гэжээ.

¹⁷ Европын холбоо

¹⁸ Terrestrial Digital Audio Broadcasting

Зөвлөмжүүд

- L зурваст тоон радиог дамжуулах талаар судалгааны баг гарган ажиллуулах
- Зурвас III(174-230MHz) нь Geneva06 хэлэлцээрийн дагуу байдаг бөгөөд зарим улсууд 230-240 MHz зурвасыг Wi95CO7 хэлцлийн дагуу ашиглах зурваст оруулж байгааг шүүн хэлэлцэх
- Европын улс орнуудад ашиглагдах хүлээн авагчуудыг олон улсын зах зээлийн шаардлагад нийцүүлэхэд анхаарах
- Европын улсуудын тоон өргөн нэвтрүүлгийн шилжилтийн явцад ЕХ ны комисс хяналт тавих
- DRM+ нарийн зурвасын стандартын өргөн нэвтрүүлгийн боломжийн талаар дахин судлах

1.6 Европын бусад улсуудын тоон технологийн шилжилтийн талаарх нөхцөл байдал

Европын бусад улс орнуудын өнөөгийн байдлыг судлан үнэлэлт өгөх нь нилээд түвэгтэй зорилт байлаа. Үүнд үнэлэлт дүгнэлт өгөхөд эдийн засгийн болон салбарын хөгжил, зохицуулалтын орчин, зах зээлийн бусад хүчин зүйлүүдийг тухайн орны харах өнцгөөс харж дүгнэх шаардлагатай байдагтай холбоотой юм.

Энэ байдал нь Европын улсуудын 2003/2004 оны үед тоон телевизийн шилжилтийн нөхцөл байдалтай олон талаараа төстэй. Судалгааны хэсгээс дараах дүгнэлтийг өгч байна:

Зах зээлийн эдийн засгийн асуудал болох маш ихээр үйлдвэрлэгдэж борлуулагдсан хүлээн авагчууд хэрэглэгчийн худалдан авах чадварын доогуур байдал, тэдний хэрэгцээ шаардлага, үйлчилгээ үзүүлэгчдийн хөрөнгө оруулалтын эрсдэлтэй нөхцөл байдал, шилжилтийн дараах хөрөнгө оруулалтыг нөхөн авах хугацааны тодорхойгүй байдал зэрэг нь бодлого гарагчдад “ASO¹⁹” зарлах боломжийг бүрдүүлэхгүй байна.

Европын орнуудад эдгээр бэрхшээлийг шийдвэрлэсэн жишээнүүдээс дурдвал Их Британи Улсад тусгай зөвшөөрлийг 2009 оноос дахин олгож эхэлсэн бөгөөд Франц, Герман улсуудад хуулийн орчинд хийсэн өөрчлөлт нь шилжилтийн үндсэн хүчин зүйл болсон байна. Зарим улсуудын тайлангаас харахад хэрэглэгчийн тоон радиогийн хүлээн авагчийн хэрэгцээг нэмэгдүүлэх аргуудыг хэрэглэсэн. Жишээлбэл: Франц улсад автомашин нийлүүлэлтэд заавал тоон радио хүлээн авагчтай байх шаардлагыг тогтоосон байна. Герман Улс DAB+ системийг улс орон даяар хэрэгжүүлэх шийдвэрийг гарган хэрэгжүүлж байна. Дани улсад DAB системийг урт хугацаанд шилжүүлэх шат дараалсан стратеги төлөвлөлтийн дагуу хэрэглэгчдийн тоон радиог сонирхон худалдан авах сонирхлыг нэмэгдүүлж DAB системээс DAB+ системд шилжүүлж байна. Хүснэгт 1-д Европын орнууд дахь зурвас I, II, III –ийн өнөөгийн хэрэглээг үзүүллээ.

2. ТООН РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ИРЭЭДҮЙ

Өнөөгийн нөхцөл байдал ирээдүйн хандлагыг тооцон судалгааны хэсгийн гаргасан дүгнэлтээс доорх хандлагуудыг тодорхойлсон байна.

2.1. Европын орнуудад баримтлах чиглэл

¹⁹ Analogy Switch Off

- Боломжийн үнэтэй, сонирхол татахуйц хэрэглээнүүдтэй, тоон болон аналого технологиудыг аль алийг дэмжиж ажилдаг хүлээн авагчуудыг хэрэглэх
- Тухайн зах зээлийн эдийн засгийн багтаамжтай хүлээн авагчийн стандарт хэрэглээг тохируулах
- Тоон радиогийн амжилттай нэвтрэлт нь олон төрлийн хэрэглээтэй контентууд, дууны өндөр чанар, шинэ үйлчилгээгүйгээр амжилттай хэрэгжих боломжгүй. (нэмэлт шинэ мэдээллүүд, мултимедиа)
- Тоон технологийн шилжилтэд машиний хөгжим, гэрийн болон зөөврийн хүлээн авагч, гар утас зэрэг хүлээн авагчуудын үнийн бодлого чухал
- Хэрэглэгчдийн нэгэн хүсэн хүлээдэг зүйл бол сонирхон сонсдог радио програмыг хаана ч хүлээн авч сонсох боломж байдаг.
- Тоон радиод шилжиж дуустал аналого тоо хамт ажиллах
- Бусад үйлчилгээнд нэмэлт үйлчилгээ байдлаар хамтруулан ашиглах боломжийг нэмэгдүүлэх

Хүснэгт 1. Европын орнуудын одоогийн хэрэглээ

Зурвас	Тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээнүүд	Тусгай зөвшөөрөлгүй үйлчилгээ	Ирээдүйд байж болох хэрэглээ	Тайлбар
Зурвас I	Аналоги телевиз, газрын хөдөлгөөнт холбоо, радар, цэргийн холбоо	Сонирхогчдын радио	Аналоги өргөн нэвтрүүлэг, DRM+, цэргийн холбоо, Шинэ технологиудад дуудлага худалдаагаар олгох	Зурвас I нь одоогоор маш бага хэрэглээтэй байна. Энэ нь долгионы характеристиктай холбоотой.
Зурвас II	ФМ өргөн нэвтрүүлэг	Богино зайн радио төхөөрөмжүүд	Аналоги өргөн нэвтрүүлэг, DRM+, HDRadio	Зурвас II ФМ өргөн зурвасын үйлчилгээнд бүрэн ашиглагдсан.
Зурвас III	Аналоги телевиз, T-DAB ²⁰ , газрын хөдөлгөөнт холбоо	Радио микрофон, PMSE ²¹ , телеметр	Өргөн нэвтрүүлэг DVB-T, DAB+;DRM+ радио микрофон, газрын хөдөлгөөнт холбоо	Зурвас III DAB стандартад ашиглагдаж байгаа бөгөөд аналог телевизүүдийг ОУЦХБ GE06 ²² төлөвлөгөөний дагуу шилжүүлсэн.
L-Зурвас	T-DAB,	PSME	DAB+ ,утасгүй микрофон, шинэ технологиуд	Маастрикийн гэрээгээр T-DAB стандартын үйлчилгээнд төлөвлөсөн

²⁰ Terrestrial DAB

²¹ Program making and special events

²² Geneva 06 (Олон улсын гэрээ)

Хүснэгт 2-д ЕХ-ны улсуудын ирээдүйн төлөвлөгөө

Улсын нэр	Зурвас I: 47-68 МГц	Зурвас II:87.5-108 МГц	Зурвас:174-230 MHz	Зурвас 1452-1479.5 МГц
Австри	Өргөн нэвтрүүлэгт ашиглаж байна. Цаашид хэрхэх нь тодорхой бус	Шийдвэрлээгүй	T-DAB	шийдвэрлээгүй
Швед	төлөвлөөгүй	төлөвлөөгүй	T-DAB болон DVB-T2	шийдвэрлээгүй
Дани	төлөвлөөгүй	төлөвлөөгүй	T-DAB	T-DAB
Кипр	төлөвлөөгүй	төлөвлөөгүй	T-DAB	T-DAB
Чех	Аналогийг унтрааж хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд олгох	ФМ-ийг унтраасны дараа хэрхэн ашиглах талаар төлөвлөгөө байхгүй	T-DAB, DVB-T	шийдвэрлээгүй
Эстони	Аналоги телевиз унтраасан	төлөвлөөгүй	T-DAB	шийдээгүй
Финланд	төлөвлөөгүй	ФМ чөлөөлөх	T-DAB, DVB-T	шийдээгүй

Франц	DRM+ trial ²³ 2009	ФМ	136 радио 2008 оноос T-DAB дээр ажиллаж байна	T-DAB, T-DMB, ESDR or DVB-SH, тоон радио микрофон
Герман			T-DAB	PMSE
Унгар			Өргөн нэвтрүүлэг T-DAB	
Ирланд	төлөвлөөгүй	төлөвлөөгүй	T-DAB	T-DAB
Итали	Хөдөлгөөнт холбоо	ФМ	T-DAB	T-DAB
Швецари	Тусгай холбоо	Өргөн нэвтрүүлэг	T-DAB	Радио микрофон
Латви	Хөдөлгөөнт холбоо	ФМ	T-DAB, DVB-T	Мултимедиа
Норвег			T-DAB	
Британи	төлөвлөөгүй	ФМ зэрэгцэн ажиллана.	T-DAB, PMR ²⁴ 193 МГц – ээс дээш	Дуудлага худалдаагаар худалдана.

²³ DRM+ туршилт

²⁴ Personal mobile radio

2.2 Улс орнуудын санал

- Тоон технологийн шилжих цаг хугацаа спектрийг тодорхой болгох
- Радио давтамжийн 80 МГц-ээс доош зурваст аналог телевизийг тоон технологид шилжүүлснээс хойшхи хэрэглээний талаар тодорхой төлөвлөгөө байхгүй байгаа тул өөр тоон телевиз эсвэл тоон радио технологи хэрэгжүүлэх боломжийг судлахыг санал болгож байна.
- Хямд үнэтэй хүлээн авагчийг зах зээлд нэмэгдүүлэх
- ЕХ-ны судалгаагаар DRM+ зурвас III –ийг ашиглах нь их хэмжээний контентийг дамжуулахад техникийн боломжгүй гэж үзсэн
- Зарим улсууд ASO өдрийг зарлаагүй байгааг залруулж ASO-г зарлах

2.2.1. Европын орнуудын судалгааны дүгнэлт

Энэ баримт бичгийн зөвлөмж, саналууд ерөнхийдөө Европын 2004 оны тоон телевизид шилжих шилжилтийн үеийнхтэй адил төстэй юм.

2.2.2. Зурвас I (47-68 МГц)

Одоогийн байдлаар зарим улсууд аналог телевизийг зогсоож амжаагүй байгаа бөгөөд батлан хамгаалах, хөдөлгөөнт холбооны үйлчилгээ, сонирхогчийн радио зэрэгт ашиглаж байна. Улс орнууд DRM+ ийн зурвас I, II дээрх хэрэглээг сонирхох сонирхол бага байна. Орон нутгийн хэрэглээнд илүү тохиромжтой гэж үзэж байна.

2.2.3 Зурвас II (87.5-108 МГц)

Европын улс орнуудын FM-ийн зурвас бөгөөд хүн ам шигүү суурьшсан хотуудад радио давтамжийн дутагдалд орсон. Харин хөдөө орон нутагт чөлөөтэй зурвасууд байгаа нутгуудад DRM+ стандартыг хэрэгжүүлэх боломжтой гэж ЕХ-ны судалгааны тайланд дурдсан байна.

2.2.4. Зурвас III (174-230 MHz)

Энд DAB/DAB+/DMB стандартуудын үндсэн давтамжийн зурвас байдаг. Зөвхөн ганц өргөн нэвтрүүлгийн DVB-T2 стандартаар тоон радио, телевизийг хамтад нь дамжуулах боломжтой юм.

3. МОНГОЛ УЛСАД VHF I, II, III ЗУРВАСЫН

РАДИО ДАВТАМЖИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 275 тоот тогтоолоор “Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан байна. Харилцаа холбооны зохицуулах хорооноос тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 2011 оны “Монгол улсад газрын тоон радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн сүлжээнд ашиглах давтамжийн зурвасын хуваарилалт батлах тухай” 43 тоот, “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт /төлөвлөгөө/-д нэмэлт оруулах тухай” 44 тоот тогтоолуудаар Монгол улсад газрын тоон радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн сүлжээнд ашиглах давтамжийн зурвас, стандартыг нарийвчлан тодорхойлсон байна. Үүнд:

Хүснэгт 3. Хэт богино долгионы зурвас /47-108 МГц/

ОУЦХБ-ын хуваарийн I-р бүс	Үндэсний хуваарилалт	Төлөвлөлт	Стратеги
47-87.5 ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ	47-87.5 ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ	Тоон технологийн DRM+ радиог 2012 оноос хөгжүүлнэ.	2011.01.01-ний өдрөөс энэхүү давтамжийн зурваст аналог телевизийн сувгийн хуваарилалт хийхгүй.
87.5-108 ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ	87.5-108 ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ	Чөлөөт давтамжийн зурваст Тоон технологийн DRM+ болон HD радиог 2012 оноос хөгжүүлнэ.	

Хүснэгт 4. Телевизийн III зурвас /174-240 МГц/

ОУЦХБ-ын хуваарийн I-р бүс	Үндэсний хуваарилалт	Төлөвлөлт	Стратеги
174-230 ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ	174-230 ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ	2011.07.01-ний өдрөөс 174-223 МГц-ийн давтамжийн зурвасыг ТООН РАДИО БОЛОН ТЕЛЕВИЗИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГТ ашиглана.	2012.01.01-ний өдрөөс аналог системийн өргөн шинээр зөвшөөрөл олгохгүй.

230-267 ХӨДӨЛГӨӨНТ БУС ХӨДӨЛГӨӨНТ	230-267 ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ ХӨДӨЛГӨӨНТ БУС ХӨДӨЛГӨӨНТ	2011.07.01-ний өдрөөс 230-240 МГц-ийн давтамжийн зурвасыг ТООН РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГТ ашиглана.	өөрчлөлт оруулахгүй
--	---	--	---------------------

3.1 VHF I,II,III зурвасын ашиглалттай холбоотой гарсан тогтоол

Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар болон Харилцаа холбооны зохицуулах хорооноос радио, телевизийн газрын сүлжээг тоон технологид шилжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд олон улсын стандарт, систем, шилжилтийн үеийн бодлогыг судалж холбогдох тогтоол, шийдвэрүүдийг гаргасан байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 275 тоот “Үндэсний хөтөлбөр батлах тухай” тогтоол;
2. Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 276 тоот “Телевиз, радиогийн зохицуулалтын талаар баримтлах чиглэл батлах тухай” тогтоол;
3. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын даргын 2005 оны 136 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Монгол Улсад телевизийн нэвтрүүлгийн тоон системээр дамжуулахад баримтлах чиглэл”;
4. 2004 онд шинэчлэн гаргасан “Монгол улсын үндэсний радио давтамжийн хуваарийн хүснэгт”-ийн төлөвлөгөө;
5. Харилцаа холбооны зохицуулах хорооны “Монгол Улсын хэмжээнд тоон телевизийн газрын сүлжээнд олон улсын тоон телевизийн DVB-T стандартыг сонгох” тухай 2006 оны 12-р сарын 48-р тоот тогтоол;
6. Харилцаа холбооны зохицуулах хорооны давтамжийн зурвас хуваарилах тухай 2007 оны 12-р сарын 62 тоот “Монгол Улсын хэмжээнд тоон телевизийн өргөн нэвтрүүлэгт ашиглах давтамжийн зурвасын хуваарилалтыг нэгдүгээр, радио өргөн нэвтрүүлэгт ашиглах давтамжийн зурвасын хуваарилалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлах” тогтоол;
7. Харилцаа холбооны зохицуулах хорооны “Монгол Улсын хэмжээнд урт, дунд, богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн газрын сүлжээнд тоон радио өргөн нэвтрүүлгийн DRM стандартыг сонгох” тухай 2007 оны 12-р сарын 64-р тоот тогтоол;
8. Харилцаа холбооны зохицуулах хорооны “Монгол Улсын хэмжээнд тоон радио өргөн нэвтрүүлгийн сансрын ба газрын сүлжээнд тоон радио өргөн нэвтрүүлгийн DAB-T, DAB-S стандартыг сонгох” тухай 2007 оны 12-р сарын 65-р тоот тогтоол;
9. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2011 оны “Монгол улсад газрын тоон радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн сүлжээнд ашиглах давтамжийн зурвасын хуваарилалт батлах тухай” 43 тоот тогтоол;

10. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2011 оны “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт /төлөвлөгөө/-д нэмэлт оруулах тухай” 44 тоот тогтоол;

3.2 Стандартууд

Монгол Улсын ХХЗХ, СХҮТ-өөс хамтран радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн сүлжээ, тоног төхөөрөмжийн талаар боловсруулан батлуулж, одоо мөрдөгдөж байгаа үндэсний 6 стандарт байдаг. Үүнд:

1. MNS 5476:2005: Давтамжийн модуляцтай радио өргөн нэвтрүүлгийн цахилгаан оронгийн хүчлэгийн хамгаалах харьцаа, зөвшөөрөх хэмжээ /Радиоогийн нэвтрүүлэгчүүдийн хоорондох радио давтамжийн хамгаалах харьцааны хэм хэмжээ ямар байхыг заасан стандарт/
2. MNS 5477:2005: Давтамжийн модуляцтай радио өргөн нэвтрүүлгийн цацаргалтын давтамжийн хамгийн их хазайлт ба түүнийг хэмжих арга /Радиоогийн нэвтрүүлэгчээс цацаргаж байгаа үндсэн давтамжийн зурвасын хэмжээ ямар байхыг тодорхойлж, түүнийг хэмжих аргачлалыг заасан стандарт/
3. MNS 5473:2005: Радио телевизийн өргөн нэвтрүүлгийн сүлжээний тооцооны арга. /30 МГц-ээс 1000 МГц-ийн давтамжийн царгаанд телевиз болон хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгийн сүлжээний тархалтын тооцоолол хийхэд ашиглагддаг/
4. MNS 4909:2000: Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн нэвтрүүлэгчийн техникийн шаардлага. /Хэт богино долгионы радиоогийн нэвтрүүлэгчүүдийн техникийн үзүүлэлтүүд ямар байхыг тодорхойлж өгсөн стандарт/
5. MNS 5591-1:2006: Радио студид тавигдах үндсэн шаардлага” стандарт
6. MNS 5591-2:2007: Радиоогийн студийн тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт” стандарт

3.3 Шилжилтийн үед VHF I,II,III зурвасуудад баримтлах зарчмын

талаар саналууд

Өмнө 2013 онд ХХЗХ-ны даргын 100 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн тайланд дараах саналуудыг тусгасан байна. Үүнд:

1. Радио өргөн нэвтрүүлэг тоон технологид шилжүүлэхдээ нэмэлт үйлчилгээг бий болгох, үйлчилгээний чанарыг сайжруулах, хамрах хүрээг өргөтгөх, харилцан нөлөөллийг бууруулах чиглэлийг баримтлан ард иргэдэд хүндрэл бэрхшээл учруулахгүйгээр үе шаттайгаар гүйцэтгэж хэрэгжүүлнэ.
2. Аналог өргөн нэвтрүүлгийн системийг тоон технологид үе шаттайгаар шилжүүлэх ба тоон технологид шилжих шилжилтийн үйл явц хангалттай түвшинд хүртэл аналог болон тоон өргөн нэвтрүүлгийн системийг зэрэгцүүлэн ажиллуулна.
3. Радио өргөн нэвтрүүлгийг ард иргэдэд тэгш, шударга зарчмын үндсэн дээр орон зай, байршлаас үл хамааран хүлээн авах нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.

4. Улсын төсөв, гадаадын зээл тусламж, бүх нийтийн үүргийн сан болон бусад хөрөнгө оруулалтаар шинээр аналог өргөн нэвтрүүлгийн системд өргөтгөл, шинэчлэл хийхгүй.
5. Зөвхөн аналог өргөн нэвтрүүлэгт ашиглагдах болон стандартад нийцээгүй тоног төхөөрөмжийн дотоодын үйлдвэрлэл, импортод хяналт тавьж, хязгаарлах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
6. Хэрэглэгчийг бодит, үнэн зөв мэдээллээр хангах үр дүнтэй мэдээлэл, зар сурталчилгааны бодлого баримтлана.

3.4 Шилжилтийн талаар ажлын хэсгийн саналууд

ХХЗХ-ны даргын тушаалаар 2011, 2013 онуудад байгуулагдан ажилласан тоон радиогийн шийдэл боловсруулах ажлын хэсгүүдийн судалгаагаар улсын хэмжээний нутаг дэвсгэрийг хамарсан сүлжээнд шинэчлэлийн үед баримтлах дараах саналууд гаргасан байна. Үүнд:

1. LF²⁵ 148.5- 283.5 кГц нь Улсын хэмжээнд аналог РӨН ашиглагдаж байгаа тул бүрэн зогсоох боломжгүйг анхаарч, цагийн ялгаатай хуваарийг ашиглах; 87.5-108 МГц царааны зарим зурваст ФМ нэвтрүүлгийг үргэлжлүүлэн цацах, 174-230 МГц царааны зарим зурваст DAB+ дамжууллыг ашиглан тоон өргөн нэвтрүүлгийг эхлүүлэх;
2. Улсын хэмжээний нутаг дэвсгэрт DRM30, DAB, DAB+ стандартуудыг тоон технологийн үндсэн стандартыг батлуулах
3. Улаанбаатар, аймгийн төвүүдэд DAB+ стандартыг хангасан нэгдсэн дамжуулах сүлжээг улсын хөрөнгө оруулалтаар байгуулах;
4. Орон нутгийн сүлжээнд DRM, DAB+ стандартыг ашиглах
5. Улаанбаатар хотод тоон радио өргөн нэвтрүүлгийн сүлжээнд нэг давтамжийн сүлжээг ашиглах, бусад бүх аймгийн төв, томоохон сум суурин газарт улсын шилэн кабелийн сүлжээг ашиглан олон давтамжийн сүлжээг зохион байгуулах;
6. Улсын хэмжээний нутаг дэвсгэрт DRM30 стандартыг ашиглан их хүчний радио станцуудыг шинэчлэх;
7. Хэрэглэгчийн хүлээн авах төхөөрөмжийг Монгол Улсад үйлдвэрлэх асуудлаар дотоод гадаадын Мэдээлэл харилцаа холбооны салбарын томоохон компаниудтай хамтран үйлдвэрлэх боломжийг судлах зэрэг саналууд гарсан байна.

4 ДҮГНЭЛТ

4.1 Зурвас I (47-68 МГц)

Манай улсад энэ зурваст РТС УТҮГ ; BTV телевиз; Багануурын амьдрал сонин зэрэг газрууд телевизийн 1,2-р сувагт 48.5-56.5 МГц; 58.0-66.0 МГц радио давтамжуудад телевизийн аналог нэвтрүүлгийг дамжуулах тусгай зөвшөөрөлтэй байна. Тоон технологид шилжиж энэ зурвасыг бүрэн чөлөөлсний дараа ямар үйлчилгээнд ашиглах талаар

²⁵ Long frequency (30-300KHz, wavelengths greater than 1000 m)

одоогоор төлөвлөөгүй байгаа бөгөөд зарим улс орнуудын жишгийг даган тусгай хэрэглээ болон хөдөлгөөнт үйлчилгээнд ашиглах боломжийг судлах шаардлагатай.

4.2 Зурвас II (87.5-108 МГц)

ФМ-ийн зурвас бөгөөд Улаанбаатар хотод радио давтамжийг бүрэн хэмжээгээр ашигласан. Хүн ам сийрэг суурьшсан орон нутагт давтамжийн нөөц хангалттай байна. Олон улсад хийгдэж байгаа тоон радиод шилжих шилжилтийн үйл явцтай уялдуулан дүгнэхэд энэ зурвасыг тоон радиогийн DRM+ стандартыг хэрэгжүүлэхэд зөвхөн туршилтаар хэрэгжүүлж байна.

Манай улс тоон радиод хийгдэх шилжилтийг тодорхой хугацаа зааж зурвас III хэрэгжүүлж эхэлсэн тохиолдолд одоогийн фм станцуудыг зэрэгцүүлэн ажиллуулах нь зүйтэй. Харин тоон технологид шилжилт хийгдэж уг зурвас бүрэн чөлөөлөгдсний дараагийн ашиглалтын талаар 1-р бүс нутгийн орнуудад тодорхой төлөвлөлт хийгдээгүй байна.

4.3 Зурвас III (174-230 МГц)

Радио давтамжийн энэ зурваст радио давтамжийн хангалттай нөөц байдаг. Одоогийн байдлаар 174-182 МГц телевизийн 6-р сувагт РТС УТҮГ телевизийн дахин дамжуулах үйлчилгээг улс орн даяар дамжуулах, 182-190 МГц зурваст телевизийн 7-р сувагт хөдөлгөөнт телевизийн үйлчилгээг УБ хотод дамжуулах эрхийг УБ-ДИ-ЭМ-БИ ХХК эзэмшдэг. Мөн түүнчлэн Ийгл ТВ, 25-р суваг , ТВ-9 зэрэг аналог телевизүүд тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Өмнөх жилүүдэд 2011, 2013 онуудад хийгдсэн ажлын хэсгүүдийн дүгнэлтээр телевизийн 9-р сувгийн (198-206 МГц) 8С (198.592-200.128 МГц), 8D (200.304-201.840 МГц), 9А (202.160-203.696 МГц), 9В (203.872-205.408 МГц) сувгуудад тоон радиогийн DAB+ стандартыг хэрэгжүүлэх техникийн шийдэл боловсруулагдсан.

1-р бүсийн орнуудын судалгаа бусад орнуудын хандлагаас харахад 174-230 МГц зурваст DAB+/DMB болон DVB-T2 тоон телевизийн үйлчилгээнүүдэд ашиглахаар төлөвлөгдсөн байна.

Зураг 1. Улаанбаатар хотод VHF I, II, III радио давтамжийн зурвасын радио давтамжийн ашиглалт

48.5 MHz	1	ВТV
58 МГц	2	МУОНРТ
76 МГц	3	Стар ТВ
84 МГц	4	
92 МГц	5	ФМ радионууд
174 МГц	6	РТСГ Д/Д
182 МГц	7	Хөдөлгөөнт телевиз
190 МГц	8	Ийгл ТВ
198 МГц	9	DAB+
206 МГц	10	25-р суваг
214 МГц	11	
222 МГц	12	ТВ-9

Эдгээр судалгаануудаас нэгтгэн дүгнэхэд бусад орнуудад ч VHF I, II, III цараанд тоон технологийн шинэчилэл хийгдсний дараах хэрэглээг тодорхойлж амжаагүй байгаа бөгөөд үүний наана тоон радиогийн стандартын сонголтыг хийж аналог системийг унтраах хугацааг тодорхойлох шаардлагатай.

Ашигласан материал

1. Working Group RSPG10-349 report “The future of radio broadcasting in Europe”;

http://www.corrierecomunicazioni.it/upload/images/10_2012/121004151717.pdf

2. Тоон радиогийн зохицуулалтын чиглэл, техникийн шийдэл боловсруулах ажлын хэсгийн тайлан; 2013 он Улаанбаатар хот, ХХЗХ

<http://crc.gov.mn/main.php?cid=1&do=227&did=0>

FUTURE TREND OF VHF I, II, III BANDS

Mongolia is included by region 1 of ITU with European countries. In terms of that we need international experiences of the regional countries and their future aspects of the strategic challenges and opportunities. So you do not hesitate to read following section.

In 11th February of 2010 the Radio Spectrum Policy Group (RSPG) of European Union decided to study in more detail the figure of radio broadcasting in Europe with a view to understand possible spectrum implication. The RSPG were sent out two questionnaires to 24 member states of the EU. The report focuses following issues related as efficient use of radio spectrum. This is done by:

1. Describing today's usage in some European countries
2. Assessing the needs and the opportunities of the sector based on the findings
3. Identifying strategic objectives for the VHF bands and 1.5 GHz
4. Identifying and proposing activities that would be beneficial for its development

Firstly, in all cases where progress is being made there has been a political interest, both in the sense that the issue has been high up on the political agenda for discussion, and that the discussion in itself has encompassed issues such as a switch-off date.

Secondly, there has been a close cooperation between the regulator and broadcasters/market interests, and

Thirdly, but probably most important to make it a "success", there is the informational part, issuing adequate information to consumers. It is here important to highlight the importance of defining consumer protection in a context of a fast evolving technology and lack of EU-wide solution. Below 27 MHz, digitalization has been introduced in different bands by using the DRM and HD Radio standards.

This report examines the needs and opportunities of frequency bands allocated to radio broadcasting service in Bands I (47-68 MHz), II (87,5-108 MHz), III (174-230 MHz) and in L Band (1452-1479.5 MHz) knowing that radio can be broadcasted over TV channels and other technologies. The work in Europe shall be undertaken within a broader view so that our work could be taken as reference by other countries that want to reuse our experiences and technologies developed, adopted and improved in Europe. The following review is therefore accompanied by the ITU International allocations for broadcasting service for Bands I, II, III and L

The lack of frequencies in the FM Band

Although the sound quality of FM radio is considered satisfactory, the lack of frequencies hinders further developments. In the medium to long term FM broadcasting can be replaced or supplemented by a digital technology, in order to overcome the lack of frequencies for FM radio.

The digitalization of radio has been, and still is, a long term process

There is no indication of any progress anywhere to cease analogue radio in the foreseeable future. The market for analogue receivers is far from declining and it is still a lucrative market while digital tries to replace it. The industry of radio receivers is based on a world market which

has adopted the common modulation standards that can produce attractive, low terminal cost for the benefit of European listeners.

